

Golomt Capital®

ДЭЛХИЙН

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ

2025.11.17

Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- АНУ-ын түүхэн дэх хамгийн урт хугацааны төрийн байгууллагын үйл ажиллагааны зогсолт Лхагва гарагийн орой Ерөнхийлөгч Доналд Трамп Засгийн газрын санхүүжилтийг ирэх 1-р сарын 30 хүртэл сунгах хуулинд гарын үсэг зурсанаар өндөрлөв.
- Хөдөлмөрийн статистикийн товчоо (BLS) мэдээлэл албан ёсоор танилцуулах хугацааг тогтоохын тулд цаг хугацаа хэрэгтэй гэж онцлоод 9-р сарын ажлын байрны тайланг 11-р сарын 20-нд, Пүрэв гарагт нийтэлнэ гэж мэдээлэв.
- Хүү буурах магадлал ингэж огцом багассан нь хөрөнгө оруулагчдыг хувьцааны зах зээлээс гарахад хүргэжээ.
- Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн энэ үргэлжилсэн доройтол нь эдийн засгийн томоохон саад хэвээр байж, өрхийн хэрэглээг сулруулж, 2023 оны эхнээс Хятадыг дагасан дефляцийн дарамтыг улам хүндрүүлж байна.
- Засгийн газар 9-р сарын сүүлээс хойш нийт 1 их наяд юань (RMB)-ийн хэрэглээг дэмжих багц баталсан бөгөөд түүний үр нөлөө ойрын хугацаанд бодитоор мэдрэгдэж эхэлнэ гэж эдийн засагчид дүгнэж байна.



S&P 500 индексийн 2025 оны таамаглал

Deutsche Bank	7,000
Société Générale	6,750
BMO Capital Markets	6,700
Bank of America	6,666
Barclays	6,600
RBC Capital Markets	6,600
Wells Fargo	6,500
Citigroup	6,500
Goldman Sachs	6,500
Morgan Stanley	6,500
JPMorgan Chase	6,500
UBS	6,400
Дундаж	6,678

Таамагласан ханшид хүрсэн.
Дээд таамаглал **7,000** байна

U.S. GOVERNMENT
SHUTDOWN ENDS

42 DAYS OF DISRUPTION
FINALLY OVER



АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.11.10-11.16

АНУ-ЫН ТҮҮХЭН ДЭХ ХАМГИЙН УРТ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗОГСОЛТ ДУУСЛАА

АНУ-ын түүхэн дэх хамгийн урт хугацааны төрийн байгууллагын үйл ажиллагааны зогсолт Лхагва гарагийн орой Ерөнхийлөгч Доналд Трамп Засгийн газрын санхүүжилтийг ирэх 1-р сарын 30 хүртэл сунгах хуулинд гарын үсэг зурсанаар өндөрлөв. Энэ мэдээ зах зээлд тулгараад байсан нэг том дарамтыг арилгасан ч Пүрэв гарагт хөрөнгийн зах зээл огцом буурсан хэвээр байв. Учир нь нөхцөл байдал бүрэн хэвийн байдалд ороход хэр хугацаа шаардлагатай нь тодорхойгүй хэвээр байна. Цагаан ордны төлөөлөгчид 10-р сарын ажлын байр болон инфляцын тайлангууд огт гарахгүй байх магадлалтай гэж мэдэгдэв. Харин Хөдөлмөрийн статистикийн товчоо (BLS) мэдээлэл албан ёсоор танилцуулах хугацааг тогтоохын тулд цаг хугацаа хэрэгтэй гэж онцлоод 9-р сарын ажлын байрны тайланг 11-р сарын 20-нд, Пүрэв гарагт нийтэлнэ гэж мэдээлэв.

АНУ-ЫН ХӨРӨНГИЙН ИНДЕКСҮҮД ХОЛИМОГ ХӨДӨЛГӨӨН ҮЗҮҮЛЭВ

АНУ-ын хувьцааны зах зээл энэ долоо хоногт холимог төлөвтэй хаагдлаа. Dow Jones болон S&P 500 индексүүд багахан өсөлттэй байсан бол Nasdaq Composite, S&P MidCap 400 болон Russell 2000 индексүүд уналттай байв. Долоо хоногийн ихэнх хугацаанд хувьцаанууд унасан хэвээр байсан нь өндөр үнэлгээний эрсдэл болон хиймэл оюуны салбар дахь зарцуулалтын нарийн хяналт хөрөнгө оруулагчдыг шийдвэрээ эргэн нэг харахад нөлөөлсөн байна.

Хэд хэдэн Холбооны Нөөцийн Банкны (ХНС) удирдлагуудын "хатуу" өнгө аястай мэдэгдлүүд зах зээлд дарамт үзүүллээ. Лхагва гарагт Атлантагийн Нөөцийн банкны ерөнхийлөгч Рафаэль Бостик хэлэхдээ хөдөлмөрийн зах зээлийн дохио "эвгүйцмээр, тайлбарлахад төвөгтэй" байгаа бөгөөд инфляцын эрсдэлтэй харьцуулахад бодлогын хүүг хурдан бууруулахад тодорхой бус байна гэж онцлов. Тэр мөн одоогийн бодлогын хүүг "бага зэрэг хязгаарлалттай" гэж үзэж, инфляци 2%-ийн зорилт руу тогтвортой буурч буй "тодорхой нотолгоо" гарах хүртэл хүүг хэвээр хадгалахыг дэмжиж буйгаа илэрхийлэв. Үүний зэрэгцээ, Сент-Луисын Нөөцийн банкны ерөнхийлөгч Альберто Мусалем бодлогын шийдвэрүүдэд "маш болгоомжтой хандах" хэрэгтэй гэж мэдэгдсэн бол Кливлендийн Нөөцийн банкны ерөнхийлөгч Бет Хаммак инфляц өндөр хэвээр байгаагаас шалтгаалан мөнгөний бодлого "тодорхой хэмжээгээр хязгаарлалттай" байх шаардлагатай гэж үзэж байна.

CME FedWatch мэдээллээр Баасан гарагийн байдлаар ХНС-гийн 12-р сарын хуралдааны дараа бодлогын хүү буурах магадлал ~46% болж буурчээ. Өмнөх баасан гарагт 67% байсан бол нэг сарын өмнө бараг 95% хүрээд байсан хүү буурах магадлал ингэж огцом багассан нь хөрөнгө оруулагчдыг хувьцааны зах зээлээс гарахад хүргэжээ. Жижиг компаниуд хүүгийн өөрчлөлтөд илүү мэдрэмтгий тул энэ долоо хоногт Russell 2000 индекс нийтдээ 1.83%-иар унав.



Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.11.10 – 11.16

ХЯТАДЫН ЭХ ГАЗРЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ УНАЛТТАЙ ХААГДАВ.

Хятадын дотоодын гол индекс бараг дөрвөн жилийн хамгийн өндөр түвшинд хүрсний дараа өнгөрсөн долоо хоногт хөрөнгө оруулагчид ашиг хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотойгоор эх газрын зах зээл буурлаа. CSI 300 индекс 1.08 хувиар, Шанхайн нийлмэл индекс 0.18 хувиар тус тус унасныг FactSet мэдээлжээ. Харин Хонконгийн Hang Seng индекс 1.26 хувиар өсөв.

Албан ёсны үзүүлэлтүүдэд эдийн засаг IV улиралд уруудаж эхэлснийг харууллаа

Хятадын статистикийн газрын сүүлийн үеийн мэдээллээр эдийн засгийн идэвх сулрав. Он гарсаар эхний 10 сард үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалт 1.7 хувиар буурсан нь тухайн хугацааны түүхэн хамгийн огцом уналт юм. Аж үйлдвэрийн үйлдвэрлэл 10-р сард өмнөх оноос 4.9 хувиар өссөн нь хүлээлтээс доогуур үзүүлэлт байлаа. Харин жижиглэнгийн борлуулалт 2.9 хувиар өсөж, дараалан тав дахь сарынхаа удаашралын давалгааг бүрдүүлэв.

Орон сууцны зах зээл уналт үргэлжилж, эдийн засгийн хүндрэлийг улам нэмэгдүүлэв

Дөрөв дэх жилдээ үргэлжилж буй Хятадын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн уналт хэвээр байна. Bloomberg-ийн мэдээлснээр улсын татаастай орон сууцаас бусад 70 хотын шинэ байрны үнэ 10-р сард өмнөх сараас 0.45 хувиар унажээ. Энэ нь нэг жилийн доторх хамгийн огцом бууралт юм. Хуучин байрны үнэ 0.66 хувиар унаж, 13 сарын хамгийн гүн уналтыг үзүүлэв. Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн энэ үргэлжилсэн доройтол нь эдийн засгийн томоохон саад хэвээр байж, өрхийн хэрэглээг сулруулж, 2023 оны эхнээс Хятадыг дагасан дефляцийн дарамтыг улам хүндрүүлж байна.

Эдийн засаг хүлээлтээс илүү суларсан ч 5 хувийн өсөлтийн зорилт хүрч болохуйц гэж үзэж байна.

10-р сарын тоонууд эдийн засаг төсөөллөөсөө илүү суларсныг харуулсан ч олон эдийн засагчид Бээжингийн энэ жилийн 5 орчим хувийн өсөлтийн зорилтыг биелүүлэх боломжтой хэвээр гэж үзэж байна. Ялангуяа өнгөрсөн сард БНСУ-д болсон хэлэлцээрийн үеэр АНУ, Хятад хоёр нэг жил худалдааны дайнаа зогсооно гэж тогтсоны дараа энэ итгэл илүү нэмэгджээ. Мөн төв засгийн газар 9-р сарын сүүлээс хойш нийт 1 их наяд юань (RMB)-ийн хэрэглээг дэмжих багц баталсан бөгөөд түүний үр нөлөө ойрын хугацаанд бодитоор мэдрэгдэж эхэлнэ гэж эдийн засагчид дүгнэж байна.

Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open
PGY PAGAYA	IGTI rigetti	NBIS NEBIUS	BYND BEYOND MEAT	CRCL CIRCLE	CSCO CISCO	DIS Disney	AMAT APPLIED MATERIALS	HIVE HIVE
B BARRICK	CRWV CoreWeave	SE sea	OKLO OKLO	ARCO Arcois Dorados	PAAAS PAN AMERICAN SILVER	BITF Bitfarms	RCAT REJO CAT	SRRK Scholar Rock
MNDV monday.com	BBAI BIGBEAR.AI	DAVA endava	LPFH LightPath	INNVZ INNOVIZ TECHNOLOGIES	GRAL GRAIL	JD JD.COM	NU NU	BTBT BIT DIGITAL
CART instacart	RKLB ROCKEFELLER LIFE SCIENCES	HSAI HESAI	EPM EVOLUTION Petroleum Corporation	GILT Gilat	ASND ascendis pharma	BLI bilibili	REKR REKOR	TWST TWIST
BXSL Blackstone Secured Lending	ASTS AST SpaceMobile	CWCO CONSOLIDATED WATER CRNT	PAL PHARMACAPLOGICS INTZ	ONON ong	SERV serve	ONDS ONDAS	SPCE GALACTIC	SR spire
BTDR BITDEER	WULF TERAWULF	CERAG CERAGON	INTRN INTRUSION	AUTL Autolus	ABSI absci	BN Brookfield	LAZR LUMINAR	SGML SIGMA LITHIUM
VFF village farms	PLUG PLUG	CVG CVG	SMWB SimilarWeb	CRMD CorMedix	LUNG pulmonX	PSFE Paysafe	GLOB Globant	SBC SBC
VG VONAGE	OXY OXY	KALV KalVista	STXS STEREOTAXIS	GFS GlobalFoundries	CCAP CRESCENT	WKSP Workspout	TMC the metals company	LMEFA LMFUNDING
EXOD EXODUS	IVST microvast	WKHS WORKHORSE	SHOJ SHOULDER	VLN Valens	CURR CurioStream	GAMB gambling.com	CODX Co-Dx	ITRM ITERUM
RAIL FREIGHTCAR AMERICA	HROW HARROW	PVLA palvello	DOX amdocs	IHS IHS	DLO d-local	EC EAGLE POINT	BZH BEAZER HOMES	INKT MiNK

http://eps.sh/cal

© 2025 Earnings Whispers

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open
ARBE arbe	TCOM Trip.com	HD HOME DEPOT	POWL POWELL	TGT TARGET	NVDA NVIDIA	WMT Walmart	BULL Webull	BJ BJ's
XPEV XPEV	GLAD GLADSTONE CAPITAL	BIDU Baidu	DLE DOLBY	WIX WIX	PNWV paloalto	ZIM ZIM	VEEV Veeva	VFST VINFAST
JKSI Jinko Solar	IBP IBP	BRRB bellring	KULR KULR	TJX TJX	NJR New Jersey Resources	SHO SHOE CARNIVAL	CPRT GoPart	FRD FRONTLINE
YMM 满帮 Full Truck Alliance	IBV VERTICALS	FUTU FUTU	CCF CARLYLE	LOW Lowe's	CPA Copa Airlines	ALIT alot	GAP Gap Inc.	AZTA AZENTA
BRC BRADY	XP XP Inc.	AS AMER SPORTS	SBLK STAR BULK	BLSH Bullish	ZTO 中通快递	ROAD elastic	ESTC UGI	MNSO MINI SOU
CRGO FREIGHTOS	DAC danans	KLAR Klarna	SQM SQM	VV Valvoline	TBBB BB	NNOX NANOX	UGI UGI CORPORATION	MOGA MOOG
ZK ZEEKR	LWMD LifeMD+	PDD Pinduoduo Inc.	VREX VREX	KC Valvoline	CRNC cerence	WMG WARNER MUSIC GROUP	INTU intuit	
CDRO codere	JHX James Hardie	QFIN QIFU	QFIN QIFU	ICCM IceCure	BYV BrightView	NTES NetEase Games	POST Post	
ARMK aramark	CAN Canaan	GBCD GOLUB CAPITAL	GBCD GOLUB CAPITAL	GDS GDS	JACK Jack	RERE 万物新生	ROST ROSS DRESS FOR LESS	
JJSF JJ SNACK FOODS	MDT Medtronic	LZB LA BOY	LZB LA BOY	VIK VIKING	IBOX In the Box	VIPS 唯品会 vip.com	NGVC NATURAL GROCEANS	

http://eps.sh/cal

© 2025 Earnings Whispers